



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023-2026 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 ОН

АГУУЛГА

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл	3
Бүлэг 2. Мандатын шинжилгээ	6
Бүлэг 3. Алсын хараа.....	8
Бүлэг 4. Эрхэм зорилго.....	8
Бүлэг 5. Орчны шинжилгээ.....	8
Бүлэг 6. Стратегийн зорилго... ..	11
Бүлэг 7. Стратегийн зорилго ба төвийн бүтэц, салбар хоорондын уялдааны зураглал.....	14
Бүлэг 8. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги	15
Бүлэг 9. Товчлол.....	23

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023-2026 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Халдварт өвчин судлалын үндэсний төв нь халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, дархлаажуулалт, тандалт, хяналт, эрдэм шинжилгээ, сургалт судалгаа, мэргэжлийн лабораторийн оношилгоо, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмчилгээний асуудлыг олон улсын жишиг нийцүүлэн үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулах, мэргэжил аргагүйн удирдлагаар хангах үүрэг бүхий тусгай мэргэжлийн төв байгууллага юм.

Монгол Улсад Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын Эрүүл Мэндийн Сайдын 2001 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 34 дүгээр тушаалаар Халдвартын клиникийн эмнэлэг, Халдварт өвчин судлалын төв, Сүрьеэгийн үндэсний төв, Сүрьеэгийн клиникийн эмнэлэг зэрэг байгууллагыг нэгтгэж Халдварт өвчин судлалын үндэсний төв /ХӨСҮТ/-ийг байгуулсан байна. Түүнчлэн Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн гүйцэтгэж байсан “Гепатит, томуу, сүрьеэ зэрэг халдварт өвчнөөс сэргийлэх, түүнийг оношлох, эмчлэх шинэ арга” сэдвүүдийг гүйцэтгэгчдийн хамт ХӨСҮТ-д 2001 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор шилжүүлэхээр шийдвэрлэжээ. ХӨСҮТ-ийг бүтэц зохион байгуулалтын хувьд бүрдүүлсэн эдгээр байгууллагууд нь Монгол Улсын Эрүүл мэндийн салбарт түүхэн үүрэг гүйцэтгэсэн өөр өөрийн баялаг түүх, арвин туршлагатай байгууллагууд учир тус төвийн суурийг нарийн мэргэжлийн, чадавхитай хүний нөөц хийгээд материаллаг баазаар бат бөх тавьсан билээ. Тиймээс Халдварт өвчин судлалын үндэсний төв нь “Олон улсын Эрүүл мэндийн дүрэм”-ийн зохицуулагч байгууллагын үүргийг гүйцэтгэн, эрүүл мэндийг дэмжих замаар хүн амыг халдварт өвчнөөс сэргийлэх, хамгаалах, халдварт өвчний тандалт судалгаа, оношилгоо эмчилгээний талаар бодлогын бичиг баримт боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хийх, томуу, томуу төст өвчин, улаанбурхан, сүрьеэ, ДОХ/БЗДХ, нян судлалын лабораториудын чиглэлээр лавлагаа төвийн үүргийг гүйцэтгэж буй мэргэжлийн байгууллага болон хөгжиж иржээ.

Тус төв нь одоогийн байдлаар Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, судалгааны үндсэн 7 албатай, Эмнэлзүй, эмнэлгийн тусламж үйлчилгээний хэвтүүлэн эмчлэх 554 ор бүхий 16 тасагтай, жилд дунджаар 12 мянган үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчилж, 500 гаруй үйлчлүүлэгчдэд мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэхээс гадна Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа, дэмжих үйлчилгээний 6 алба, 2 тасаг нэгж гэсэн бүтэцтэйгээр нийт 730 гаруй үндсэн орон тооны ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд тус төвийн хувьд томоохон хэмжээний судалгаа, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний үндсэн дээр Халдварт өвчний илрүүлэг, эмчилгээ нэмэгдэн тархалтыг тодорхой хэмжээнд барьж чадсан байна. Тухайлбал:

- 10000 хүн амд ногдох сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдлын түвшин сүүлийн жилүүдэд тогтмол буурч байгаа ба 2012 онд улсын дундаж 14.6 байсан бол 2021 онд улсын дундаж 7.0 болж буурсан бол уушгины нян судлалаар батлагдсан сүрьеэгийн шинэ тохиолдлын эдгэрэлт 79.7%, нас баралт 2.9%, үр дүнгүй 6.6%, хяналт алдагдалт 5.2%, эмчилгээний амжилт 85.0% байна. Мөн 2012-2021 онд рифампицин буюу олон эмэнд тэсвэртэй

сүрьеэ (Риф/ОЭТС)-ийн нийт 2256 тохиолдол бүртгэгдэж, улсын хэмжээнд 100.000 хүн ам дахь Риф/ОЭТС-ийн бүртгэгдсэн тохиолдлын түвшин 2012-2014 онд өсөж байсан бол 2015 оноос хойш жигд буурсан үзүүлэлттэй байна. Риф/ОЭТС-ийн эмчилгээний амжилтын үзүүлэлт 2013-2020 онд дунджаар 63.5% байсан бол 2021 онд 72.3% болж өссөн нь 2013 оноос хойших хамгийн өндөр эерэг үзүүлэлт болж байна. Сүүлийн жилүүдэд **“Сүрьеэгийн тархалтын үндэсний судалгаа”**, **“Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн тандалт судалгаа-III”** зэрэг үндэсний хэмжээний томоохон судалгаануудыг амжилттай хэрэгжүүлж, нотолгоонд суурилсан бодлогын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ирсэн. 2002 оноос хойш Глобаль сангийн дэмжлэгтэй 9 удаагийн төслийг амжилттай хэрэгжүүлж, сүрьеэгийн оношилгоо, эмчилгээний чадавхыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүргэсэн байна.

- Монгол улс нь НҮБ-ын ДОХ-ын Нэгдсэн Хөтөлбөрийн ангиллаар ХДХВ-ийн халдварын тархалт нийт хүн амын дунд бага, харин эрсдэлт бүлгийн хүн амын дунд төвлөрсөн тархалттай орны тоонд багтдаг. ХДХВ-ийн халдварын анхны тохиолдол Монгол улсад 1992 онд бүртгэгдсэнээс хойш 2022 оны 12 дүгээр сарын 31-ны байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 346 тохиолдол бүртгэгдсэн ба ХДХВ/ДОХ-той 58 хүн нас барсан байна. Нийт бүртгэгдсэн тохиолдлын 36% нь 2013-2017 оны таван жилд бүртгэгдэж байсан бол сүүлийн таван жилд 27% болж бүртгэгдсэн тохиолдол 9 хувиар буурчээ. Энэ нь манай улсад 2013 оноос эхлэн хэрэгжүүлж буй ХДХВ-ийн халдвартай хүмүүст **“Эмчилгээ - Урьдчилан сэргийлэлт”** хөтөлбөр амжилттай хэрэгжсэнийг илтгэх нааштай үр дүн юм.
- Цочмог вируст гепатитын өвчлөл 2011 онд хамгийн их буюу нэг жилд 14,600 гаруй хүн өвдөж, 10 мянган хүн ам дахь өвчлөлийн түвшин 52.8 байсан бөгөөд дийлэнх өвчлөлд гепатитын А вирус халдвар зонхилж бүртгэгдсэн. 2012 оноос гепатитын А вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулалт хийснээр 2021 онд цочмог гепатитын өвчлөл 10 мянган хүн амд 0.4 болж буурсан байна. ДЭМБ-аас 2030 он гэхэд гепатитын В, С вирус шинэ халдварын илрүүлгийг 90%-д хүргэх, нас баралтыг 65% хүртэл бууруулах, 5 хүртэлх насны хүүхдүүдийн дундах HBsAg тархалт <0.1 болгох, В эсрэг вакцины 24 цагийн тун, 3 тунгийн хамралтыг >90% болгох зорилтуудын хүрээнд Монгол улсын хэрэгжүүлэх үйл ажиллагаа, зорилго, зорилтыг тодорхойлон **“Элэг бүтэн Монгол”** арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- Хүн амын дунд ялангуяа бага насны хүүхдүүдийн дунд түгээмэл тохиолддог хоол боловсруулах замын халдварт өвчин, хоол, хүнсний шалтгаант хордлогот халдвар, амьсгалын замын халдварт өвчний тандалтын тогтолцоог сайжруулах, сургууль, цэцэрлэг зэрэг хүүхдийн байгууллагуудад тандалтын тогтолцоог бий болгох, халдвараас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэн цусан суулгын өвчлөлийн түвшинг 2025 он гэхэд 10 мянган хүн амд 4.0 хүртэл бууруулахаар ажиллаж байна.
- Монгол улсад Талбарын тархвар судлал хөтөлбөрийг ЭМЯ, ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр 2009 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд хөтөлбөрийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, тогтвортой байдлыг хангах үүднээс 2012 онд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн бүтцэд албан ёсоор оруулахаар шат дараатай үйл ажиллагаа хэрэгжүүлсэн. Улмаар 2013 онд тус төвийн Хүн, мал эмнэлгийн талбарын

тархвар судлалын алба албан ёсоор байгуулагдаж, талбарын тархвар судлаач мэргэжил 2016 онд үндэсний мэргэжлийн жагсаалтад орсноор 2020 онд албан ёсоор төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжил олгох сургалт болж амжилттай хэрэгжиж байна. Талбарын тархвар судлалын сургалт нь зөвхөн эрүүл мэнд төдийгүй мал эмнэлэг, бусад салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэж салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэдэг ба 2022 оны байдлаар нийт 87 мэргэжилтэн талбарын тархвар судлаач мэргэжлээр суралцаж төгсөөд байна. Мөн түүнчлэн Талбарын тархвар судлалын сургалтын хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлийн үнэлгээнд хамруулж, олон улсын сургалтын итгэмжлэлтэй хөтөлбөр болгох зорилт тавин ажиллаж байна.

Энэхүү стратеги төлөвлөгөөний зорилго нь Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болох Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цаашдын хөгжлийн чиг хандлага, 2023-2026 он хүртэлх хугацаанд баримтлах Стратегийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүний чиглэлийг тодорхойлоход оршино. Уг зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж, төлөвлөгөөнд тусгасан болно. Үүнд:

- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хэмжээнд өнөөгийн тулгамдсан асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх;
- Хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээг тодорхойлох мандатын шинжилгээ хийх, ерөнхий чиг үүрэг, үндсэн чиг үүрэг, дэд чиг үүргийг нарийвчлах;
- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хөгжлийн өнөөгийн байдалд SWOT шинжилгээ хийж, давуу болон сул талыг эрэмбэлэх;
- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн стратегийн зорилт, уялдаа холбоо, нийтлэг асуудлыг судлах, хүрэх үр дүнг тооцох;
- Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хүрэх түвшин, үнэлэх шалгуур үзүүлэлтийг нарийвчлах;
- Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлох;
- Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад оролцогч талуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны уялдааг харуулах.

Тус төвийн үзүүлж байгаа ба шинээр үзүүлэх тусламж, үйлчилгээ болон тасаг, албадын үйл ажиллагаагаа шинэчлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх байдлаар 2023-2026 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөсөн болно. Уг төлөвлөгөө амжилттай хэрэгжсэнээр эдийн засгийн өсөлтийг дэмжсэн эрх зүйн шинэтгэл гүнзгийрч, мэргэшсэн, чадварлаг хүний нөөц бүрэлдэн, цахим засаглалыг хөгжүүлэх замаар хүн, нийгмийн амар тайван, аюулгүй байдал хангагдана.

Төвийн Стратеги төлөвлөгөөг оновчтой, бодитой боловсруулахын тулд байгууллагын тулгамдсан асуудлыг тодорхойлж, улс орны эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн чиг хандлага, туршлагыг судалж, хүртээмжтэй өсөлт, тасралтгүй хөгжилд чиглэсэн зорилтот түвшин, хүрэх үр дүнг тооцоолсон.

Бодлогын зорилт, үйл ажиллагааг тодорхойлохдоо ач холбогдлоор нь эрэмбэлэн, хэрэгжүүлэхэд гарч болох саад бэрхшээлүүдийг урьдчилан тооцож, хариу авах арга хэмжээг судалж, төлөвлөгөөнд тусгасан болно.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 350 дугаар тогтоолоор баталсан “Төвлөрлийг сааруулах төрөөс баримтлах бодлого”, 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагын чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 401 дүгээр тушаалаар “Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дүрэм, бүтэц”-ийг баталсны дагуу мандатын шинжилгээг хийсэн.

Мандатын шинжилгээгээр Халдварт өвчин судлалын үндэсний төвийн чиг үүргийг дараахь байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Ерөнхий чиг үүрэг: Халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, тандах, хариу арга хэмжээ авах

Үндсэн чиг үүрэг: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

Үндсэн чиг үүрэг: Эмнэлгийн тусламж, үйлчилгээ

Үндсэн чиг үүрэг: Сургалт, эрдэм шинжилгээ судалгаа

Чиг үүргийн дахин хуваарилах аргачлалын дагуу хийгдсэн дүн шинжилгээг үндэслэн төвийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль эрхзүйн орчны хүрээнд мандатын шинжилгээг дараах байдлаар хийв.

Төвийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		118
Үүнээс:	Тухайн салбарын шууд хамаарах хуулийн тоо	16
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо (бусад холбогдох хуулийн тоо)	112
Ерөнхий чиг үүрэг: ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАНДАХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	Халдварт өвчнийг тандах, сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа	ЭМЯ, ЭМДЕГ, бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд, олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, иргэд
	Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт, сурталчилгаа	
Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	Эмчлэх тусламж, үйлчилгээ	ЭМЯ, ЭМДЕГ, бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд, олон улсын байгууллагууд, ТББ, иргэд
	Шинэ технологи, инноваци нэвтрүүлэх үйл ажиллагаа	
Сургалт, эрдэм шинжилгээ судалгаа	Сургалтын үйл ажиллагаа	ЭМЯ, ЭМХТ, бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд, олон улсын
	Эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа	

		байгууллагууд, төрийн бус байгууллагууд, судалгааны байгууллагууд, иргэд
--	--	--------------------------------------------------------------------------------------

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Олон улсын түвшинд халдварт өвчний бодлогыг тодорхойлогч үндэсний төв болно.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэн, халдварт өвчний тандалт, сэргийлэлт, оношилгоо, эмчилгээнд дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлж, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, хүний нөөцийн тогтвортой хөгжил, чанар, аюулгүй байдлыг тасралтгүй хангана.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Төвийн өнөөгийн байдлыг тодорхойлох, цаашид хүрэхээр зорьж байгаа зорилго, хэрэгжүүлэх стратегийг тодорхойлох, тулгамдсан асуудлыг төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлэхийн тулд дотоод болон гадаад орчны хувьд давуу ба сул тал, боломж ба эрсдэлийг тодорхойлсон нөхцөл байдлын шинжилгээг холбогдох судалгаа баримтад үндэслэн хийв.

НЭГ. ДОТООД ОРЧИН	
ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
1. Бүтэц, зохион байгуулалтын хувьд:	
<ul style="list-style-type: none">Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, чиг үүргийг дүрмээр зохицуулсан.Үндэсний хэмжээн дэх Халдварт өвчний төрөлжсөн, мэргэшсэн, сургагч үндэсний төв.Эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн бэлддэг их дээд сургуулиуд болон эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх байгууллагуудтай хамтран ажилладаг.	<ul style="list-style-type: none">Халдварт өвчнөөс хамааран зарим үйл ажиллагаа явуулахад хязгаарлагддаг.Халдварт өвчний эмнэлэг гэсэн нийтлэг ойлголтоос болж хэрэглэгчид бусад халдварт бус өвчний эмнэлгийн тусламж, үйлчилгээг авах дургүй.Таван өөр байгууллагыг нэгтгэн үүссэн төв учир ажилтнуудын тархай бутархай байдлаас үүдэлтэй олон бие даасан соёл бүрэлдэн тогтсон.Гүйцэтгэлийн санхүүжилт хэрэгжээд 2 жил болсон боловч Эрүүл мэндийн даатгал хариуцсан тусдаа алба байхгүй.
2. Хүний нөөцийн хувьд:	
<ul style="list-style-type: none">Чадварлаг, туршлагатай, мэргэшсэн хүний нөөцтэй.Хүний нөөцийн хөгжлийн болон нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг ил тод, шалгуур үзүүлэлтийн дагуу явуулдаг.Шинэ ажилтны ажлын байрны дадлагажих хөтөлбөртэй.	<ul style="list-style-type: none">Эрүүл мэндийн сайдын тушаалаар бүтэц, орон тоог баталдаг учир хүний нөөцийн хувьд бие даасан бодлого хэрэгжүүлэхэд хүндрэлтэй.Сувилагч болон эмнэлгийн нарийн мэргэжлийн эмчийн орон тоонд хүний нөөц байнга дутагдалтай байдаг.

<ul style="list-style-type: none"> Олон улсын төсөл, хөтөлбөр байнга хэрэгждэг тул ажилтнууд төслийн ажил хавсран гүйцэтгэдэг. 	<ul style="list-style-type: none"> Эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүй, зөвлөгөө өгөх ур чадвар сул.¹ Аливаа шинэ зүйлийг сэтгэх, харьцуулах, өөрчлөлтийг хүлээж авах, дасан зохицохдоо удаан. Ажлын байрны ачаалал их, бага хүний нөөцөөр их ажил гүйцэтгүүлдэг. Хүний нөөцийн ялангуяа удирдах түвшний ажлын байр тогтворгүй. Гүйцэтгэлээр санхүүждэг боловч гүйцэтгэлээрээ цалинжих боломж бүрдээгүй.
3. Санхүүжилтийн хувьд:	
<ul style="list-style-type: none"> Байгууллагын өртөг зардлыг өртгийн төв бүрээр хуваарилдаг. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэр төрөл олширсон, үйлчлэх хүрээ нэмэгдсэн. Эрүүл мэндийн даатгалаас санхүүжилтээ тогтоосон цаг хугацаандаа авдаг. Үйл ажиллагааны орлого, төлбөрт үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэн. 	<ul style="list-style-type: none"> Эмч мэргэжилтнийг мэргэшүүлэх, хөгжүүлэх, засвар, үйлчилгээ тохижилт болон тоног төхөөрөмжийн шинэчлэлд зарцуулах санхүүжилт хүрэлцээгүй. Тандалт, судалгааны албадын санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгал болон улсын төсвөөс санхүүжүүлдэггүй. Гүйцэтгэлийн санхүүжилттэй боловч санхүүгийн бие даасан байдал байхгүй.
4. Мэдээллийн технологийн хувьд:	
<ul style="list-style-type: none"> Төвийн дотоод сүлжээни хүчин чадлыг бүрэн шинэчилсэн, мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан. Халдварт өвчний цахим сан бий болсон. Өвчний түүх бичилт цахимжсан. Шинжилгээ, оношилгооны хариуг цахимаар, цаасаар авах боломжтой. Цахим дотоод сүлжээ, камер, ухаалаг самбар зэрэг техник технологийн нөөц хүчин чадал сайтай. 	<ul style="list-style-type: none"> Цахим тогтолцоог өргөжүүлэхэд серверт гаднаас хандах боломжгүй, хязгаарлагдмал байна. ЭМДЕГ, ЭМХТ, НЭМГ-тай нэгдсэн цахим серверийн холболтгүй учир цахим программ давхар ашигладаг. Халдварт өвчин тус бүрээр цахим сантай, нэгтгээгүй. Мэдээллийн бааз хөрвөлт зарим тохиолдолд алдаатай гардаг. Байгууллагын цахим хуудсыг бүрэн шинэчлээгүй, мэдээлэл авах модуль тодорхой бус байна.
ХОЁР. ГАДААД ОРЧИН	
БОЛОМЖ	ЭРСДЭЛ
1. Эдийн засгийн хувьд:	
<ul style="list-style-type: none"> Гүйцэтгэлээр санхүүжихтэй холбоотойгоор тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулж ажилтан, алба хаагчдын цалин урамшууллыг нэмэгдүүлэх боломжтой. 	<ul style="list-style-type: none"> Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж буурах, үйлчлүүлэгчдийг өөр эмнэлэгт алдах, улмаар орлого буурах эрсдэлтэй. Шинэ болон дахин сэргэж буй халдварууд ОУ-ын эрүүл мэндийн

¹ Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа 2022 он

<ul style="list-style-type: none"> ▪ Санхүүжилтээр арга хэмжээ бүрийг төлөвлөн дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хувьд шаардлагатай шинэчлэлийг тухай бүр хийх боломжтой. ▪ Алсын зай оношилгооны төвөөр дамжуулан эрт илрүүлэг, оношилгоог хөгжүүлэх, өргөжүүлэх боломжтой. 	<p>дүрмээр зохицуулагддаг халдварт өвчнүүд илрэх, тархах магадлалтай.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Эдийн засгийн байдал, инфляциас шалтгаалан эм, эмнэлгийн хэрэгслийн үнэд нөлөөлөх эрсдэлтэй. ▪ Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд олон байгууллага оролцдог, чиг үүргийн хуваарилалт хангалтгүй тул биелэлт бүрэн гүйцэт хэрэгжихгүй байх магадлалтай. ▪ Дотоодын зах зээлд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлт бага, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл бага.
<p>2. Нийгэм, соёлын орчны хувьд:</p>	
<ul style="list-style-type: none"> ▪ Хүн амын шилжих хөдөлгөөн их байгаагаас хамааран нийслэл хотын хүн амын бөөгнөрөл их болсон, хүн амын өсөлт өндөр, дундаж наслалт нэмэгдэж байгаагаас хамааран зорилтот үйлчлүүлэгчийн тоо нэмэгдсэн. ▪ Ковид-19 цар тахлын улмаас нийт хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг хийлгэх тоо ихэссэн. 	<ul style="list-style-type: none"> ▪ Хүн амын соёлын нөлөөнөөс хамаарч БЗХД/ДОХ болон бусад халдварт өвчний талаар сөрөг ойлголттой, илрүүлэг оношилгоонд хамрагдах дургүй.
<p>3. Хууль, эрхзүйн хувьд:</p>	
<ul style="list-style-type: none"> ▪ Гадаадын хууль эрхзүйн байдал халдварт өвчний оношилгоонд түлхэц өгдөг. ▪ Хэлэлцүүлгийн түвшинд байгаа Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн батлагдсанаар тус төвийн халдварт өвчний тандалт, сэргийлэлтийн албадын тандаот, сэргийлэлт, хариу арга хэмжээний санхүүжилтийг улсын төсвөөс шийдвэрлэх боломж бүрдэнэ. 	<ul style="list-style-type: none"> ▪ Судалгаагүй, нотолгоогүй, уялдаа холбоогүй хууль, тогтоол батлагдан гардаг. ▪ Шинэ оношилгоо, эмчилгээ нэвтрүүлэхэд ЭМДҮЗ-ийн тогтоолын жагсаалтад ороогүй учир санхүүжилт өгдөггүй.
<p>4. Техник, технологийн хувьд:</p>	
<ul style="list-style-type: none"> ▪ Оношилгоо эмчилгээ, мэс заслын дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн. ▪ Үндэсний хэмжээнд өөр байгууллагад байхгүй оношилгоо, эмчилгээ хийдэг. ▪ Шинээр гарсан шилдэг, шинэ техник, технологийг нэвтрүүлэх боломжтой. ▪ Хэрэглэгчийн хувийн мэдээллийг хадгалах, хэрэглэгчтэй харилцах шинэ гарцыг нээх боломжтой. ▪ Судалгаа, шинжилгээнд зарцуулах хөрөнгө оруулалтыг Засгийн газар болон олон улсын байгууллагаас шийдвэрлүүлэх боломжтой. 	<ul style="list-style-type: none"> ▪ Одоо ашиглаж байгаа физик эмчилгээ, чих хамар хоолойн кабинетийн аппаратууд, суурин рентгенүүд зэрэг тоног төрөөхөмж нь хэт хуучирсан, хэрэглээний шаардлага хангахгүй болсон. ▪ Унтуулгын аппарат доголдсон, шинээр худалдан авахад өртөг өндөр байна.

5. Улс төрийн бодлогын хувьд:	
<ul style="list-style-type: none"> ▪ Халдварт өвчны хувьд төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ их. ▪ Төвийн нөөцийг ашиглан хийсэн судалгаа, шинжилгээний бүтээлд оюуны өмчийн гэрчилгээ авч бүртгэлжүүлэх боломжтой. ▪ Гадаад харилцаа, Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа сайтай. 	<ul style="list-style-type: none"> ▪ Улс төрийн орчны тогтворгүй байдал нь хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулдаг. ▪ Нэг худалдан авагчийн систем нь чөлөөт зах зээлийн өрсөлдөөнийг үгүй болгосон. ▪ Улс төрийн байдлаас хамаарч мэргэжлийн байгууллагын удирдлага, бүтэц зохион байгуулалт алдагдах, үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй.
6. Хүрээлэн буй орчны хувьд:	
<ul style="list-style-type: none"> ▪ Монгол орны өргөн уудам нутаг дэвсгэрт таран байршсан хүн ам зүйн тогтолцоо нь халдварт өвчний тархалтыг багасгах, барьж тогтоох боломжийг үүсгэдэг. 	<ul style="list-style-type: none"> ▪ Хүйтний улиралд амьсгалын замын халдварт өвчин дэгддэг тул өвчлөмтгий эрсдэлтэй бүлгийн иргэд илүү өвчлөл ихсэх, хүндрэх, нас барах магадлал өндөр. ▪ Хүчтэй шуурга, салхинд байгууллагын гадна фасад, чулуу, шил хагарах, биет хохирол учрах эрсдэлтэй. ▪ Төвийн байршил газар хөдлөлтийн өндөр эрсдэлтэй бүсэд байдаг тул газар хөдлөлтөд өртөх эрсдэлтэй.

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

6.1. Стратегийн зорилго

6.1.1 Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, оношилгоо, эмчилгээнд дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, хүний нөөцийн тогтвортой хөгжил, чанар аюулгүй байдлыг тасралтгүй хангах;

6.2. Стратегийн зорилт

Дээрх стратегийн зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

6.2.1 Эрүүл мэндийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй цар тахал, шинэ болон сэргэж буй халдвар, бусад халдварт өвчний тандалт, сэргийлэлт, хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх;

6.2.2 Эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийж эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлтийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх;

6.2.3 Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд удирдамж, зааврыг чанд мөрдөж, чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах;

6.2.4 Оношилгоо, шинжилгээний чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх

6.2.5 Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт шинэ технологи, инновацийг нэвтрүүлж нутагшуулах;

6.2.6 Хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжих;

6.2.7 Эрдэм шинжилгээ, судалгааны түвшинг олон улсын жишигт хүргэх;

Дээрх зорилтуудыг биелүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

6.2.1 Эрүүл мэндийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй цар тахал, шинэ болон сэргэж буй халдвар, бусад халдварт өвчний тандалт, сэргийлэлт, хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх;

6.2.1.1 Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллах;

6.2.1.2 Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэх

6.2.1.3 Нийгэм сэтгэлзүйн багийн үйлчлүүлэгчдэд зөвөлгөө өгөх орчныг сайжруулах

6.2.1.4 Сүрьеэгийн тандалтын тоо мэдээг бодит хугацаанд цуглуулах боломжтой болгох

6.2.1.5 Сүрьеэгийн эрсдэлт бүлэгт чиглэсэн идэвхтэй илрүүлэг үзлэг жил бүр зохион байгуулах

6.2.1.6 Ретровирусийн эсрэг эмчилгээний заалттай ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэх

6.2.1.7 Төрөлхийн тэмбүү өвчний тохиолдлын тоог 100 000 амд төрөлтөд 50-аас доош түвшинд барих

6.2.1.8 Эрсдэлт бүлгийн хүн амыг БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах

6.2.1.9 Нийт хүн амд БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээнд “Калл Про” үйлчилгээг нэвтрүүлэх

6.2.1.10 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд санал өгөх

6.2.1.11 Дэлхий нийтээр халдварт саа өвчнийг устгах хүртэл “Халдварт саа өвчнийг устгасан байдал”-аа хадгалахын тулд тандалтыг хийх

6.2.1.12 Улаанбурхан, улаанууд өвчнийг эрс бууруулах, устгах хүрээнд цочмог халууралт тууралттай хам шинжийн тандалтыг хийх

6.2.1.13 Хүний папилома вирусын эсрэг вакциныг үе шаттайгаар нэвтрүүлэх

6.2.2 Эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийж эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлтийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх;

6.2.2.1 Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах

6.2.2.2 Аймаг, дүүргийн эмнэлгүүдэд дэмжлэгт хяналтыг хийх

6.2.2.3 Сүрьеэтэй өвчтөн болон гэр бүлийн гишүүдэд сэтгэлзүйн зөвлөгөө өгөх

6.2.2.4 ХДХВ-ийн халдварыг илрүүлэх оношилгооны шинэ аргыг сургалт, сурталчилгааг эрсдэлт бүлгийн иргэдэд олгох

6.2.3 Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд удирдамж, зааврыг чанд мөрдөж, чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах;

6.2.3.1 Зонхилон тохиолдох халдварт өвчний эмнэлзүйн удирдамж, зааврыг шинэчлэн батлуулж, мөрдөх

6.2.3.2 Сүрьеэ өвчний эмнэлзүйн удирдамж, зааврыг шинэчлэн батлуулж, мөрдөх

6.2.3.3 “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, элэгний делта вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулах

6.2.3.4 Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлэх

6.2.3.5 Сүрьеэгийн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлэх

6.2.3.6 Сүрьеэгийн далд халдварын эмчилгээг сайжруулах

6.2.4 Оношилгоо, шинжилгээний чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх

6.2.4.1 Олон улсын чанарын гадаад хяналтанд хамрагдах

6.2.4.2 Үндэсний хэмжээнд халдварт өвчний Иммунологи, Нян судлал, Вирус судлал, Сүрьеэгийн оношлогооны чиглэлээр чанарын гадаад үнэлгээг зохион байгуулах

6.2.4.3 Эсийн дархлааны маркерийг тодорхойлох шинжилгээг хийх

6.2.5 Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт шинэ технологи, инновацийг нэвтрүүлж нутагшуулах;

6.2.5.1 Уушгины бус (нуруу нугас) сүрьеэгийн мэс заслын бэхэлгээт болон нөхөн сэргээх эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх

6.2.5.2 Мэс заслын үеийн рентген хяналтыг нэвтрүүлэх

6.2.5.3 Нурууг хөдөлгөөнгүй болгож ар талаас мэс засал хийх арга /Transpedicular screw fixation/-ыг нэвтрүүлэх

6.2.5.4 Нурууны бэхэлгээт мэс заслыг нэвтрүүлэх

6.2.5.5 Сүрьеэгийн микобактери, SARS-CoV-2, томуугийн вирус, амьсгалын замын синциталь вирусын бүрэн геномын дараалал тогтоох NGS шинжилгээний аргачлал нэвтрүүлэх

6.2.5.6 Хепатит делта вирусын ачаалал тодорхойлох шинжилгээг хийж, делта вирусын үүсгэгчээр цаашид үндэсний чанарын гадаад үнэлгээ хийх, энтеровирусын үүсгэгчийг илрүүлэх шинжилгээнд ПГУ аргыг нэвтрүүлэх

6.2.6 Хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжих;

6.2.6.1 Байгууллагын хүний нөөцийн 2025 он хүртэлх төлөвлөлтийг тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээнд тулгуурлан, олон улсын стандартад нийцүүлэн хийх

6.2.6.2 Эмчилгээ, оношилгоо, сургалт, хурал, зөвлөгөөнд алсын зайн анагаах ухааныг хэрэгжүүлэх

6.2.6.3 Төрөлжсөн мэргэшил эзэмшүүлэх сургалт зохион байгуулах

6.2.6.4 Үндсэн мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулах

6.2.6.5 Төгсөлтийн дараах албан сургалтын эрх шинээр авах

6.2.6.6 Талбарын тархвар судлалын сургалтыг өргөжүүлэх, лабораторийн эмч нарын хөтөлбөрийг боловсруулах, богино хугацааны сургалтын модуль боловсруулж, эхлүүлэх

6.2.7 Эрдэм шинжилгээ, судалгааны түвшинг олон улсын жишигт хүргэх;

6.2.7.1 Монгол Улсад тархаж байгаа коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлох, вакцинжуулалтын дараах дархлаа тогтоцын байдлыг үнэлж, дархлаа тогтох хугацааг тодорхойлох


6.2.7.2 Халдварт бус өвчин (чихрийн шижин)-тэй иргэдийн дундах сүрьеэгийн халдварын тархалт, сүрьеэгийн эмчилгээний үр дүнг судлах

6.2.7.3 Жил бүр Эрдмийн чуулган зохион байгуулах


6.2.7.4 Олон улсын болон дотоодын сэтгүүлүүдэд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх

6.2.7.5 Олон улсын мэргэжлийн байгууллага /International Hospital Federation/-ын гишүүнчлэлтэй болох


ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА ТӨВИЙН БҮТЭЦ, САЛБАР ХООРОНДЫН УЯЛДААНЫ ЗУРАГЛАЛ
7.1 Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны зураглал



7.2 Халдварт өвчин судлалын үндэсний төв, салбар хоорондын уялдааны зураглал



7.3 Халдварт өвчин судлалын үндэсний төвийн бүтэц



Төлөвлөгөөг баталсан:ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
/Албан тушаал/

Тэмдэг

.....
/Гарын үсэг/**Төсвийн ерөнхийлөн захирагч**

/С.ЧИНЗОРИГ/

/Он, сар, өдөр/

.....

Төлөвлөгөөг боловсруулсан:ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
/Албан тушаал/

Тэмдэг

.....
/Гарын үсэг/**Төсвийн шууд захирагч**

/Ц.БИЛЭГТСАЙХАН/

/Он, сар, өдөр/

.....

**ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
2023-2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
Ерөнхий чиг үүргийн нэр: ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАНДАХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ						
Үндсэн чиг үүргийн нэр: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ						
1	Зорилт 1.1. Эрүүл мэндийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй цар тахал, шинэ болон сэргэж буй халдвар, бусад халдварт өвчний тандалт, сэргийлэлт, хариу арга хэмжээний	Арга хэмжээ 1: Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллана.	Хэрэгжилтийн хувь	Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр 2017-2020 хэрэгжиж дууссан.	Хэрэгжилтийг жил бүр тайлагнаж, хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувьд хүргэж ажилласан байна.	Улсын төсөв
2	Зорилт 1.1. Эрүүл мэндийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй цар тахал, шинэ болон сэргэж буй халдвар, бусад халдварт өвчний тандалт, сэргийлэлт, хариу арга хэмжээний	Арга хэмжээ 2: МУТЖҮЧ-2.4.1, ЗГҮАХ-1.1.3 Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.	Нөөцөлсөн эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурын нэр төрөл, хугацаа	Нөөцийн бэлэн байдлыг эм, эмнэлгийн хэрэгсэл тус бүрээр тухай	Цар тахлын үеийн нөөцийн бэлэн байдлын үнэлгээ хийж, нөөцийг	-

	чадавхийг бэхжүүлнэ.			бүрд тооцон гаргаж байна.	шинэчилж сэлгэж бүрдүүлсэн байна.	
3		Арга хэмжээ 3: Нийгэм сэтгэлзүйн багийн үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгөх орчныг сайжруулна.	Тохижуулсан сүрьеэгийн диспансерын хувь	БГД, СХД-ийн сүрьеэгийн диспансерт нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөх өрөө тохижуулсан.	Нийт 8 диспансерт зөвлөгөө өгөх өрөө тохижуулсан байна.	Олон улсын байгууллага
4		Арга хэмжээ 4: Сүрьеэгийн тандалтын тоо мэдээг бодит хугацаанд цуглуулах боломжтой болгоно.	Сүрьеэгийн диспансерын шилжсэн хувь	50 хувь байсан.	Сүрьеэгийн нийт диспансерыг 100 хувь шилжүүлсэн байна.	Олон улсын байгууллага
5		Арга хэмжээ 5: Сүрьеэгийн эрсдэлт бүлэгт чиглэсэн идэвхтэй илрүүлэг үзлэг жил бүр зохион байгуулна.	Бүртгэгдсэн шинэ болон дахилтад сүрьеэгийн тохиолдол	19 хувь байсан.	Эрсдэлт бүлгийн 50 хувийг илрүүлэгд хамруулсан байна.	-
6		Арга хэмжээ 6: Ретровирусийн эсрэг эмчилгээний заалттай ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Ретровирусийн эсрэг эмчилгээний заалттай ХДХВ-ийн халдвартай хүмүүсээс эмчилгээнд хамруулсан хувь	Ретровирусийн эсрэг эмчилгээний заалттай ХДХВ-ийн халдвартай хүмүүсээс эмчилгээнд хамруулсан хувь 92 байна.	Ретровирусийн эсрэг эмчилгээний заалттай ХДХВ-ийн халдвартай хүмүүсээс эмчилгээнд хамруулсан хувь 93 байна.	Үйл ажиллагааны зардал
7		Арга хэмжээ 7: Төрөлхийн тэмбүү өвчний тохиолдлын тоог 100 000 амд төрөлтөд 50-аас доош түвшинд барина.	100 000 амд төрөлтөд төрөлхийн тэмбүү өвчтэй төрсөн хүүхдийн тоо	100 000 амд төрөлтөд төрөлхийн тэмбүү өвчтэй төрөх хүүхдийн тоо 46 байсан.	100 000 амд төрөлтөд төрөлхийн тэмбүү өвчтэй төрөх хүүхдийн тоо 45 болсон байна.	Үйл ажиллагааны зардал
8		Арга хэмжээ 8: Эрсдэлт бүлгийн хүн амыг БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх арга хэмжээ зохион байгуулна.	Хамрагдсан ЭБЭ, ЭБҮ-ийн хувь	ЭБЭ - 78% ЭБҮ – 82% байна.	ЭБЭ - 80% ЭБҮ – 84% байна.	Олон улсын байгууллагаас 28 сая төгрөг
9		Арга хэмжээ 9: Нийт хүн амд БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээнд “Колл Про” үйлчилгээг нэвтрүүлнэ.	Хамрагдалтын хувь	-	Нийт 1200 хүнийг хамруулсан байна.	Олон улсын байгууллагаас 7980 ам доллар

10		Арга хэмжээ 10: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд санал өгнө.	Хүргүүлсэн санал	Хууль байхгүй.	ЭМЯ-нд саналыг албан бичгээр хүргүүлсэн байна.	-
11		Арга хэмжээ 11: Дэлхий нийтээр халдварт саа өвчнийг устгах хүртэл “Халдварт саа өвчнийг устгасан байдал”-аа хадгалахын тулд тандалтыг хийнэ.	Цочмог сул саажилтыг илрүүлж мэдээлсэн тохиолдлын тоо	5 сэжигтэй тохиолдол илрүүлсэн.	Нийт 20 сэжигтэй тохиолдол илрүүлсэн байна.	Улсын төсөв, олон улсын байгууллагаас
12		Арга хэмжээ 12: Улаанбурхан, улаанууд өвчнийг эрс бууруулах, устгах хүрээнд цочмог халууралт тууралттай хам шинжийн тандалтыг хийнэ.	Холбогдох эрүүл мэндийн байгууллагын хувь	Холбогдох эрүүл мэндийн байгууллагын 20 хувь хамрагдаж байсан.	Холбогдох эрүүл мэндийн байгууллагын 60 хувийг тандалтад хамруулсан байна.	Улсын төсөв, олон улсын байгууллагаас
13		Арга хэмжээ 13: Хүний папилома вирусын эсрэг вакциныг үе шаттайгаар нэвтрүүлнэ.	Нэвтрүүлсэн аймаг, дүүргийн хувь	Нэвтрүүлээгүй.	Нийт 10 аймаг, дүүрэгт нэвтрүүлсэн байна.	Улсын төсөв, олон улсын байгууллагаас
14	Зорилт 1.2. Эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийж эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлтийн талаарх мэдлэгийг дээшлүүлнэ.	Арга хэмжээ 1: МУЗГХ-1.1.3.3. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна.	Мэдээлэл, сургалт, сурталчилгааны тоо	-	Мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулж халдвараас урьдчилан сэргийлсэн байна.	Улсын төсөв, олон улсын байгууллагаас
15		Арга хэмжээ 2: Аймаг, дүүргийн эмнэлгүүдэд дэмжлэгт хяналтыг хийнэ.	Хамрагдалтын хувь	Аймаг, дүүргийн эмнэлгүүдийг 60 хувь	Аймаг, дүүргийн эмнэлгүүдэд дэмжлэгт хяналт хийгдсэн байна.	Улсын төсөв, олон улсын байгууллагаас
16		Арга хэмжээ 3: Сүрьеэтэй өвчтөн болон гэр бүлийн гишүүдэд сэтгэлзүйн зөвлөгөө өгнө.	Хамрагдалтын хувь	Нийт 4 гэр бүлд зөвлөгөө өгч байсан.	Сүрьеэгийн эмч, мэргэжилтнүүдийн 60 хувийг сэтгэлзүйн зөвлөгөө өгөх чадвартай болгосон байна.	Олон улсын байгууллагаас 576 сая төгрөг

17		Арга хэмжээ 4: ХДХВ-ийн халдварыг илрүүлэх оношилгооны шинэ аргыг сургалт, сурталчилгааг эрсдэлт бүлгийн иргэдэд олгоно.	Хамрагдалтын хувь	-	Эрсдэлт бүлгийн 3600 хүнд сургалт, сурталчилгаа хийсэн байна.	Олон улсын байгууллагаас 31 сая төгрөг
Үндсэн чиг үүргийн нэр: Эмнэлгийн тусламж, үйлчилгээ						
18	2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд удирдамж, зааврыг чанд мөрдөж, чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулна.	Арга хэмжээ 1: Зонхилон тохиолдох халдварт өвчний эмнэлзүйн удирдамж, зааврыг шинэчлэн батлуулж, мөрдөнө.	Шинэчлэн батлагдсан эмнэлзүйн удирдамж, заавар	2016 оны халдварт өвчний тандалт, судалгаа, оношилгоо, эмчилгээний стандартыг мөрдөн ажилладаг.	Халдварт өвчний эмнэлзүйн шинэчлэгдсэн удирдамж, зааврыг мөрдөн ажилласан байна.	Улсын төсвөөс 30 сая төгрөг
19		Арга хэмжээ 2: Сүрьеэ өвчний эмнэлзүйн удирдамж, зааврыг шинэчлэн батлуулж, мөрдөнө.	Шинэчлэн батлагдсан эмнэлзүйн удирдамж, заавар	2021 оны сүрьеэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, зааврыг мөрдөн ажилладаг.	Сүрьеэ өвчний эмнэлзүйн шинэчлэгдсэн удирдамж, зааврыг мөрдөн ажилласан байна.	Улсын төсвөөс 30 сая төгрөг
20		Арга хэмжээ 3: МУТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ-2.1.1 “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, элэгний делта вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулна.	Хэрэгжилтийн хувь	Төлөвлөлтийн шатанд байна.	Арга хэмжээний хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна.	-
21		Арга хэмжээ 4: МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-2.1.3 Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлнэ.	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	Барилгын зураглал, техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн. Газрын асуудал баталгаажсан.	Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна.	-
22		Арга хэмжээ 5: Сүрьеэгийн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлнэ.	Үйлчлүүлэгчийн тоо	-	Сүрьеэгийн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний тасаг нээж, үйлчилгээ үзүүлсэн байна.	Олон улсын байгууллагаас 115 сая төгрөг

23		Арга хэмжээ 6: Сүрьеэгийн далд халдварын эмчилгээг сайжруулна.	Далд халдварын эмчилгээний хамрагдалтын хувь	2021 оны жилийн эцсийн байдлаар 177 тохиолдол эмчилгээнд хамруулсан.	Далд халдварын эмчилгээнд хамрагдалт өмнөх оноос 50 хувиар нэмэгдсэн байна.	-
24	Зорилт 2.2. Оношилгоо, шинжилгээний чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Арга хэмжээ 1: Олон улсын чанарын гадаад хяналтад хамрагдана.	Чанарын гадаад хяналтад хамрагдсан байдал	Австрали улсын үндэсний лавлагаа лабораторийн (NRL EQAS) чанарын хяналтын хөтөлбөр Хепатитын В, С вирус, ДОХ, тэмбүүгийн чанарын хяналтаар хамрагдсан.	Чанарын гадаад хяналтад хамрагдан гэрчилгээ авсан байна.	Үйл ажиллагааны зардлаас 100 сая төгрөг
25		Арга хэмжээ 2: Үндэсний хэмжээнд халдварт өвчний Иммунологи, Нян судлал, Вирус судлал, Сүрьеэгийн оношилгооны чиглэлээр чанарын гадаад үнэлгээг зохион байгуулна.	Чанарын гадаад хяналтын гэрчилгээ	Нийт 125 лаборатори хамрагдсан.	Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй лабораторийн 70-аас дээш хувийг үнэлгээнд хамруулсан байна.	Үйл ажиллагааны зардлаас 100 сая төгрөг
26		Арга хэмжээ 3: Эсийн дархлааны маркерийг тодорхойлох шинжилгээг хийнэ.		-	Ретровирусын эмийн эмчилгээнд вирусын геномын дарааллыг тогтоож, мутацийг илрүүлсэн байна.	Олон улсын байгууллагаас 400 сая төгрөг
27	Зорилт 2.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт шинэ технологи, инновацийг нэвтрүүлж нутагшуулна.	Арга хэмжээ 1: Уушгины бус (нуруу нугас) сүрьеэгийн мэс заслын бэхэлгээт болон нөхөн сэргээх эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлнэ.	Мэс заслын дараах хөдөлмөрийн чадвар алдалт 14 хоног болсон тохиолдлын тоо	Мэс заслын сөрөг даралттай өрөөний их засвар дуусаж хүлээн авсан.	Сүрьеэгийн мэс заслын бэхэлгээт болон нөхөн сэргээх эмчилгээ нэвтрүүлснээр хөдөлмөрийн чадвар алдалт 6 сараас 14 хоног болж буурсан байна.	Үйл ажиллагааны зардлаас 290 сая төгрөг
28		Арга хэмжээ 2: Мэс заслын үеийн рентген хяналтыг нэвтрүүлнэ.	Рентген хяналттай хийсэн мэс заслын тоо	-	Зөөврийн рентген аппаратаар мэс заслын үеийн	Олон улсын байгууллага

					хяналтыг хийдэг болсон байна.	
29		Арга хэмжээ 3: Нурууг хөдөлгөөнгүй болгож ар талаас мэс засал хийх арга /Transpedicular screw fixation/-ыг нэвтрүүлэх	Мэс заслын тоо	-	Мэс заслыг хийж эхэлсэн байна.	Эрүүл мэндийн яамны санхүүжилтээс 280 сая төгрөг
30		Арга хэмжээ 4: Нурууны бэхэлгээт мэс заслыг нэвтрүүлнэ.	Мэс заслын тоо	-	Мэс заслыг хийж эхэлсэн байна.	Эрүүл мэндийн яамны санхүүжилтээс 280 сая төгрөг
31		Арга хэмжээ 5: Сүрьеэгийн микобактери, SARS-CoV-2, томуугийн вирус, амьсгалын замын синциталь вирусын бүрэн геномын дараалал тогтоох NGS шинжилгээний аргачлал нэвтрүүлнэ.	Сүрьеэ судлалын оношилгоо, судалгаа, тайлан	Бэлтгэл ажлыг хангаж, 3 эмчийг сургалтанд хамруулсан.	NGS технологийг нутагшуулж, туршилт шинжилгээ судалгаа хийж, сүрьеэгийн микобактерийн омогт бүрэн геномын сиквэнс хийсэн байна.	Үйл ажиллагааны зардал 800 сая төгрөг болон SATREPS төсөл
32		Арга хэмжээ 6: Хепатит делта вирус ачаалал тодорхойлох шинжилгээг хийж, делта вирус үүсгэгчээр цаашид үндэсний чанарын гадаад үнэлгээ хийх, энтеровирус үүсгэгчийг илрүүлэх шинжилгээнд ПГУ аргыг нэвтрүүлнэ.	Хепатит Делта вирус болон Тууралтат халдварын үүсгэгчдийн оношилгоо, шинжилгээ, тайлан	Бэлтгэл ажлыг хангаж, аппарат тоног төхөөрөмжийг тохируулах 2 эмчийг сургалтад хамруулсан.	ПГУ аргыг нэвтрүүлж, хепатит В, С, D вирус геномын дарааллыг тодорхойлдог болсон байна.	Үйл ажиллагааны зардлаас 100 сая төгрөг
Үндсэн чиг үүргийн нэр: Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа						
33	Зорилт 3.1. Хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.	Арга хэмжээ 1: Байгууллагын хүний нөөцийн 2025 он хүртэлх төлөвлөлтийг тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээнд тулгуурлан, олон улсын стандартад нийцүүлэн хийнэ.	Хүний нөөцийн 2026 он хүртэлх батлагдсан тооцоо, төлөвлөлт	Өмнө нь гаргасан хүний нөөцийн урт хугацааны тооцоо, төлөвлөлт 2020 онд дуусгавар болсон.	Хүний нөөцийн 2026 он хүртэлх тооцоо, төлөвлөлт хийгдсэн байна.	-

34	Арга хэмжээ 2: Эмчилгээ, оношилгоо, сургалт, хурал, зөвлөгөөнд алсын зайн анагаах ухааныг хэрэгжүүлнэ.	Алсын зайнаас эмчилгээ, оношилгоо хийсэн тохиолдлын тоо	-	Алсын зайн эмчилгээ, оношилгоо тогтмолжуулсан байна.	Олон улсын байгууллага
35	Арга хэмжээ 3: Төрөлжсөн мэргэшил эзэмшүүлэх сургалт зохион байгуулна.	Сургалтад хамрагдсан хүний тоо	2021 онд дархлаажуулалтын сувилахуй судлал, халдвартын сувилахуй судлал, ариутгал судлал сургалтад 552 сувилагч хамрагдаж төрөлжсөн мэргэшил эзэмшсэн.	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед дайчлагдан ажиллах 120 сувилагчийг дархлаажуулалтын сувилахуй судлал, халдвартын сувилахуй судлал, ариутгал судлал чиглэлээр төрөлжсөн мэргэшил эзэмшүүлсэн байна.	Сургалтын төлбөр
36	Арга хэмжээ 4: Үндсэн мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулна.	Сургалт, хамрагдсан хүний тоо	2021 онд Резидентийн сургалтаар 37 эмч төгссөн.	Халдварт, сүрьеэгийн эмч дутагдалтай эрүүл мэндийн байгууллагын 30 эмчийг хамруулсан байна.	Сургалтын төлбөр
37	Арга хэмжээ 5: Төгсөлтийн дараах албан сургалтын эрх шинээр авна.	Сургалтын эрхийн тоо	Сургалт явуулж байгаагүй, Эрүүл мэндийн сайдын А/337 дугаар тушаалын 7, 8, 9 дэх заалтын шалгууруудыг хангасан.	Сургалтын эрх авч, 5 эмч сургаж эхэлсэн байна.	Үйл ажиллагааны зардлаас 4 сая төгрөг
38	Арга хэмжээ 6: Талбарын тархвар судлалын сургалтыг өргөжүүлэх, лабораторийн эмч нарын хөтөлбөрийг боловсруулах, богино	Бэлтгэгдсэн талбарын лабораторийн болон эпидемиологчдийн тоо	КОВИД-19 цар тахалтай холбоотой богино хугацааны сургалтын модуль боловсруулж дууссан байна.	Талбарын лабораторийн болон эпидемиологчдийг бэлтгэсэн байна.	-

		хугацааны сургалтын модуль боловсруулж, эхлүүлнэ.				
39	Зорилт 3.2. Эрдэм шинжилгээ, судалгааны түвшинг олон улсын жишигт хүргэнэ.	Арга хэмжээ 1: МУТАҮЧ-2.4.1, ЗГҮАХ-1.1.2 Монгол Улсад тархаж байгаа коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлох, вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын байдлыг үнэлж, дархлаа тогтох хугацааг тодорхойлно.	Судалгааны үр дүн, нийтлэл	Судалгаа эхлэх шатанд байна.	Вакцинжуулалтын дараах дархлаа тогтоцын байдлыг үнэлж, дархлаа тогтох хугацааг тодорхойлж, үр дүнг олон улсын сэтгүүлд хэвлүүлсэн байна.	ЭМЯ-ны хөрөнгө оруулалт, 2.1 тэрбум төгрөг
40		Арга хэмжээ 2: Халдварт бус өвчин (чихрийн шижин)-тэй иргэдийн дундах сүрьеэгийн халдварын тархалт, сүрьеэгийн эмчилгээний үр дүнг судална.	Судалгааны үр дүн, нийтлэл	-	Судалгааны үр дүнг гаргаж, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө гаргасан байна.	
41		Арга хэмжээ 3: Жил бүр Эрдмийн чуулган зохион байгуулна.	Бүтээлийн хураангуй	Жил бүр уламжлал болгон явуулдаг.	Эрдмийн чуулган зохион байгуулж, бүтээлийн хураангуй гарсан байна.	Төсөл хөтөлбөр
42		Арга хэмжээ 4: Олон улсын болон дотоодын сэтгүүлүүдэд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлнэ.	Олон улсын болон дотоодын сэтгүүлүүдэд хэвлүүлсэн өгүүллийн тоо	Урьд жилүүдийн тоо баримт тодорхойгүй.	Олон улсын болон дотоодын сэтгүүлүүдэд хэвлүүлсэн өгүүллийн тоо 80 байна.	-
43		Арга хэмжээ 5: Олон улсын мэргэжлийн байгууллага / International Hospital Federation/-ын гишүүнчлэлтэй болно.	IHF гишүүнчлэлийн гэрчилгээ	Гишүүнчлэл байхгүй.	IHF гишүүнчлэлтэй болж, үйл ажиллагаанд орсон байна.	Үйл ажиллагааны зардлаас 3 сая төгрөг

---oOo---

ЕС. ТОВЧЛОЛ

ИHR /ОУЭМД/ APSED /ХӨТАНДБС/ WHO /ДЭМБ/ ШУА ЭМЯ ЭМХТ АШУУИС АУХ ХӨСҮТ EWAR /ЭСХАХАТ/ БЗДХ ХДХВ/ДОХ ОЭТС НЭМГ АЭМГ БОЭТ ТББ НЭМҮТ ЭБЭ ЭБҮ	Олон улсын эрүүл мэндийн дүрэм Халдварт өвчинтэй тэмцэх Ази номхон далайн бүсийн стратеги Дэлхийн эрүүл мэндийн байгууллага Шинжлэх ухааны академи Эрүүл мэндийн яам Эрүүл мэндийн хөгжлийн төв Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль Анагаах ухааны хүрээлэн Халдварт өвчин судлалын үндэсний төв Халдварт өвчний эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоо Бэлгийн замаар дамжих халдвар Хүний дархлал хомсдолын вирус, Дархлалын олдмол хомсдол Олон эмэнд тэсвэртэй сүрьеэ Нийслэлийн эрүүл мэндийн газар Аймгийн эрүүл мэндийн газар Бүсийн оношлогоо, эмчилгээний төв Төрийн бус байгууллага Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв Эрэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд ордог эрэгтэйчүүд Эмэгтэй биеэ үнэлэгч
------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------